

2022 оны Сургуулийн бонд



Сонгуулийн өдөр буюу 11-р сарын 8-ны өдөр сургуулийн өнөөгийн дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх зорилгоор 165.01 сая долларын сургуулийн бондыг батлах эсэх талаар Арлингтоны тойргийн сонгогчдын саналыг асуух болно. Үүнээс гадна сургуулийн бондоор Арлингтоны Карьерын төвийн орон тооны сурагчид болон, АТӨС-иудын бүх ахлах сургуулийн сурагчид үйлчлэх, ирээдүйд нэмэгдэх сурагчдыг хүлээн авахад бэлдэх шинэ байгууламжийг санхүүжүүлэх юм. АТӨС-иудын барилга байгууламжуудыг сурагчдын өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах, өндөр чанартай боловсролыг дэмжих зорилгоор засаж сайжруулдаг бөгөөд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах давхар үүрэг хүлээдэг учраас уг сургуулиудад хөрөнгө оруулдаг юм.

2022 оны Сургуулийн Бондоос босгосон хөрөнгө нь Арлингтон дахь сургуулиудын хэрэгцээг хангахад хэрхэн туслах вэ?

2022 оны сургуулийн бондын сангууд нь сургуулийн одоо байгаа дэд бүтцийг сайжруулах, шинэчлэхэд чиглэсэн тогтмол хөрөнгө оруулалтыг жил бүр санхүүжүүлж, Арлингтон дахь Карьерын төвийн удаан хүлээгдэж буй шинэ барилгыг барих төлөвлөгөөг санхүүжүүлэх болно. Түүнчлэн Сургуулийн бонд нь бидний нэн тэргүүний зорилт болох одоогийн АТӨС-иудын барилга байгууламжийг үргэлжлүүлэн сайжруулах, шинэчлэх талаарх АТӨС-иудын төлөвлөгөөг дэмжих болно. Сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах төслүүд нь төлөвлөсөн ажлын ихэнх хэсгийг бүрдүүлдэг билээ. Шинэчилж сайжруулсан гал тогоо нь сурагчдыг газар дээр нь бэлтгэсэн шинэ жимс, хүнсний ногоо агуулсан сайн чанартай хоол идэх боломжийг олгох болно. Нэвтрэх хэсэг болон хамгаалалтын үүдний танхимын шинэчлэлтүүд нь одоогийн аюулгүй байдлын стандартад нийцсэн байх бөгөөд бүх зочдод төв байраар нэвтрэн орох боломж олгоно.

Сургуулийн бонд ямар зарчмаар ажилладаг вэ?

Хувь хүн эсвэл айл өрхийн авдаг моргейжийн зээлийн нэгэн адил бонд нь том хэмжээний шинэчлэлийн ажлын зардлыг хэдэн жилийн турш санхүүжүүлдэг урт хугацааны зээл юм. Урт хугацааны хөрөнгө оруулалтыг (сургуулийн барилга барих гэх мэт) бондоор төлөх нь сургуульд хийгдэж буй хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх одоогийн болон ирээдүйн татвар төлөгчдийн дунд зардлыг хуваарилдаг давуу талтай.

2022 оны сургуулийн бондоос босгосон хөрөнгийг хэрхэн ашиглах вэ?

165.01 сая ам.долларыг дараах төслүүдэд зарцуулна.


- Халаалт, агааржуулалт, сэрүүцүүлэх систем, цахилгаан, гэрэлтүүлэг, дээвэр, цонх зэрэг томоохон дэд бүтцийн төслүүд - Санхүүжилт: 16.8 сая доллар
- Аюулгүй байдлын өнөөгийн стандартад нийцүүлэх болон сурагчдыг эрүүл хоолоор хангах үүднээс нэвтрэх хэсэг/хамгаалалтын үүдний танхимын шинэчлэл, гал тогооны засварын ажил. - Санхүүжилт: 16.36 сая доллар (4.12 сая долларыг 2021 оны сургуулийн бондын санал асуулгад оруулсан)
- Арлингтон Карьерын төвийн (ACC) бүтэн цагаар сурдаг сурагчид болон Арлингтоны Карьерын Төв болон Карьер болон Техникийн Боловсролын (СТЕ) курст элсэн суралцаж буй бүх АТӨС-иудын ахлах сургуулийнханд зориулсан сурагчийн сурах үйл ажиллагааг дэмжих орчин үеийн барилга барих Арлингтон Карьерын Төв Төсөл – Санхүүжилт: \$135.97 Сая

Сургуулийн бонд нь Их Засварын Төлөвлөгөө (CIP)-тэй хэрхэн холбогдох вэ?

2022 оны сургуулийн бондын санал асуулга нь 165.01 сая долларыг босгохын тулд хийгдсэн бөгөөд 2023-2032 оны санхүүгийн жилийн Их Засварын Төлөвлөгөөнд (CIP) багтсан Арлингтоны Карьерын шинэ төв зэрэг АТӨС-иудын төрөл бүрийн томоохон төслүүдийг санхүүжүүлнэ. Харин 2022 оны сургуулийн бонд нь 2023-32 оны санхүүгийн жилийн CIP-ийн зарим төслүүдийг санхүүжүүлэх боловч 2023-32 оны санхүүгийн жилийн CIP нь үндсэндээ 10 жилийн хугацаанд одоо байгаа АТӨС-иудын байгууламжийн төслүүдэд төвлөрөх бөгөөд ирээдүйн сургуулийн бонд зэрэг янз бүрийн эх үүсвэрээс санхүүжих юм.

2023-32 оны санхүүгийн жилийн CIP нь санхүүжилтийг дараах байдлаар хуваарилсан байна.

- Урт хугацааны засварын төлөвлөгөөний ирээдүйн санхүүжилтийг оруулалгүйгээр одоо байгаа байгууламжийг сайжруулахад 55%
- 45 хувийг Арлингтоны Карьерын Төвийн төсөл (шинэ барилга, талбай, машины зогсоол)





2022 оны Сургуулийн бонд

<p>Өмнөх бондуудаар АТӨС-иудын ямар төслүүдийг санхүүжүүлсэн бэ?</p>	<p>Арлингтоны олон нийтээс баталсан өмнөх бондууд нь өнөөгийн сургуулийн барилгуудын засвар, өргөтгөл, түүнчлэн шинэ барилга барих, түүний дотор хамгийн сүүлийн үеийн дараах төслүүдийг санхүүжүүлэхэд чухал үрэг гүйцэтгэсэн болно.</p> <ul style="list-style-type: none"> • АТӨС-иудын боловсролын төв байсан Вашингтон-Либерти өргөтгөлд ахлах сургуулийн 600 суудал нэмсэн (2022 оны 8-р сард нээгдсэн) • Кардинал бага сургуулийн барилгын ажил (2021 оны 8-р сард ашиглалтад орсон) • Тээврийн ажилтнуудын байгууламжийн шинэчлэл (2021 оны 3-р сард нээгдсэн) • Дороти Хаммын дунд сургуулийн өргөтгөл болон засварын ажил (засварын ажил 2019 оны 9-р сард нээгдсэн; өргөтгөл нь 2020 оны 9-р сард нээгдсэн) • Н-В Woodlawn болон Shriver хөтөлбөрүүдийг байрлуулах The Heights-ийн барилгын ажил (2019 оны 9-р сард нээгдсэн) • Алис В.Флитийн бага сургуулийн барилгын ажил (2019 оны 9-р сард нээгдсэн) • Абингдон бага сургуулийн өргөтгөл, засвар (2018 оны 1-р сард дууссан) • Мкинли бага сургуулийн засвар, өргөтгөл (2016 оны намар дууссан) • Дисковери бага сургуулийн барилгын ажил (2015 оны намар ашиглалтад орсон)
<p>АТӨС-иудын Их засварын төлөвлөлтийн үйл явцад COVID-19 тахал хэрхэн нөлөөлсөн бэ?</p>	<p>2023-2032 оны санхүүгийн жилийн CIP нь сурагчийн элсэлтийг нэмэгдүүлэхэд голчлон төвлөрөөгүй сүүлийн 10 жилийн анхны CIP бөгөөд АТӨС-иудын сурагчдын амжилт, сайн сайхан байдалд анхаарлаа хандуулж буй юм. Сурагчдын суралцах явцад дэмжлэг үзүүлэх өндөр чанартай сургалтын орчныг бүрдүүлэхийн тулд 2023-2032 оны санхүүгийн жилийн CIP нь сургуулийн одоо байгаа дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх зорилгоор жил бүр тогтмол хөрөнгө оруулалт хийх бөгөөд мөн удаан хүлээгдэж буй Арлингтоны Карьерын Төвийн шинэ барилгыг барих төлөвлөгөөнд онцгойлон анхаарал хандуулах болно. 2023-2032 оны санхүүгийн жилийн CIP нь АТӨС-иудын одоогийн ашиглаж буй барилга байгууламжуудыг үргэлжлүүлэн сайжруулах, шинэчлэх ажлыг нэн тэргүүний зорилт болгон хэрхэн төлөвлөж байгааг харуулсан болно. Сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг сайжруулах төслүүд нь төлөвлөсөн ажлын ихэнх хэсгийг бүрдүүлдэг.</p>
<p>Өсөн нэмэгдэж буй элсэлт дагуу сургуулийн чадавхийг нэмэгдүүлэхийн тулд АТӨС-иуд Арлингтон тойргийн засаг захиргаатай хэрхэн хамтран ажиллаж байна вэ?</p>	<p>АТӨС-иуд нь Гурвалсан А (AAA) бондын үнэлгээтэй Арлингтон тойрогтой үргэлжлүүлэн нягт хамтран ажиллаж, уг тойрог сурагчдын сурах үйл ажиллагааг үр дүнтэй дэмжих сургуулийн барилгын хэрэгцээг хангахад зорин ажиллаж байна. АТӨС-иуд нь Арлингтон тойргоос гаргасан өр зээлтэй холбоотой бүх бодлогыг баримтлан ажилладаг. АТӨС-иуд нь зөвлөх хороотой нягт хамтран ажилладаг бөгөөд хөрөнгийн сайжруулалтыг санхүүжүүлэхийн тулд Арлингтон дүүргийн ирээдүйн хэрэгцээг хянаж, шийдвэрлэхэд цогцоор ханддаг.</p>
<p>АТӨС-иудад хүүхэд нь сурдаггүй й Арлингтоны оршин суугчдад сургуулийн бонд хэр хамааралтай вэ?</p>	<p>Хэдийгээр бүх оршин суугчийн хүүхэд манай сургуулиудад сурдаггүй ч эдгээр айл өрхүүдэд хүүхэд нь АТӨС-иудыг төгссөн эсвэл ирээдүйд хүүхдээ уг сургуулиудад өгөхөөр төлөвлөж буй гэр бүлүүд багтдаг. Манай сургуулиудын хүчирхэг тогтолцоо дэмжих хөрөнгө оруулалтууд нь Арлингтон тойргийн оршин суугч бүрт хоёр үндсэн хэлбэрээр ашиг тусаа өгдөг.</p> <ol style="list-style-type: none"> 1. АТӨС-иудын барилга байгууламжуудыг олон нийтийн зориулалтаар ашиглах - АТӨС-иудын барилга байгууламжуудыг Арлингтон тойргийн нийт иргэд жилд 58,000 гаруй цагаар ашигладаг, үүнд: усан спортын байгууламж дахь олон нийтийн гишүүнчлэл; Арлингтон дүүргийн цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газруудын оройн болон амралтын өдрүүдийн хөтөлбөрүүд; сурагчдын амралтын үеэр амралтын болон зуны кэмп маягаар ашиглах мөн олон нийтийн үзэсгэлэн, урлагийн арга хэмжээ болон бусад тусгай уулзалтуудыг зохион байгуулдаг. 2. Эдийн засгийн нөлөөлөл - Сургуулийн үйл ажиллагаа болон их засварт зориулсан санхүүжилт нь оршин суугч нь АТӨС-иудад сурдаг хүүхдүүдтэй эсэхээс үл хамааран Арлингтон тойргийн ирээдүйд нөлөөлдөг. Эдийн засагч доктор Майкл Уолдены 2013 онд хийсэн судалгаагаар АТӨС-иудын их засварын төлөвлөгөөнд зарцуулсан нэг сая доллар бүр Арлингтон хотод 10.4 ажлын байр бий болгохтой холбоотой болохыг тогтоожээ. Цаашилбал, АТӨС-иудын сурагчдын сурлага сайжирсан нь үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэ, татварын орлого нэмэгдэхэд хүргэсэн. Сүүлийн үед Nestlé зэрэг томоохон корпорацууд болон Амазон нь сургуулийн системийн чанар нь Арлингтонд оффисоо байгуулах шийдвэрт гол хүчин зүйл болсон хэмээн мэдэгджээ.
<p>Дэлгэрэнгүй мэдээлэл хаанаас авах боломжтой вэ?</p> <p>2022 оны Сургуулийн Бондын би хэрхэн дэмжиж болох вэ?</p>	<p>2022 оны сургуулийн бондын тухай болон 2023-32 оны санхүүгийн жилд АТӨС-иудын Их Засварын Төлөвлөгөөнд (CIP) төлөвлөсөн бүх төслүүдийн талаарх мэдээллийг www.apsva.us/CIP цахим хуудаснаас авах боломжтой.</p> <p>Сургуулийн бондыг 2021 оны 11-р сарын 2-ны сонгуулийн санал хураалтын хуудсанд багтаасан болно. Санал өгөх гурван арга байдаг:</p> <ul style="list-style-type: none"> • Саналаа эрт өгөх: 2022 оны 9-р сарын 23-наас эхлэн Арлингтон тойргийн таван байршлаас сонгоно. • Шуудангаар: 2022 оны 10-р сарын 28-ны дотор саналын хуудас авах хүсэлт гаргах • Өөрийн биеэр: Санал авах байранд 2022 оны 11-р сарын 8-нд – 6 а.м-7 р.м цагийн хооронд ажиллана. <p>Байршлыг олох эсвэл шуудангаар санал өгөх хүсэлт гаргах бол: vote.arlingtonva.us хаягаар хандана уу.</p>